



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2019 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 20

Мандалговь

“Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээ”  
ОНӨҮГазрын удирдах зөвлөлийг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн 18.1.3 а, ж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийн 21.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг: Дундговь аймгийн “Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээ” орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

- УЗ-ийн дарга                    Н.Эрдэнэ-Очир / Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /
- Гишүүдэд                        Б.Мөнхжаргал / Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга /  
    Н.Мядагмаа / Дэрэн сумын Засаг дарга /  
    Г.Соёл-эрдэнэ / Иргэний төлөөлөл /
- Нарийн бичиг                    Ц.Даваа / Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн /

Хоёр: Орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн баталсан дүрмийг мөрдөж ажиллахыг Удирдах зөвлөлд даалгасугай.

Гурав: Энэ тогтоол гарсантай холбогдуулж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 10 дугаар сарын 06-ны 228 дугаар тогтоолоор батлагдсан дүрмийн 3.1.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай

ДАРГА  С.СҮХБААТАР

480219055